

## МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Ярилцлага өгөгчийн нэр	Гончиг овогтой Чиндэг	Дугаар	L235
Оршин суугаа аймаг	Өмнөговь	Оршин суугаа сум	Баяндалай сум
Төрсөн газар	Баяндалай сум	Төрсөн он	1927
Ажил мэргэжил	өндөр настан		
Лам байсан эсэх, Шавилан сууж байсан сүм хийд	Очирдарь хувилгааны хийд	Сүм хийдийн дугаар	ӨГБД 017
Одоогийн сүм хийд		Сүм хийдийн дугаар	
Ярилцлага авсан он сар өдөр	2007 оны 6-р сарын 8	Ярилцлага авсан хүн	Ц.Гантулга

Өмнөговь аймгийн Баяндалай сумын Гүж ламын хийд буюу Очирдарь хувилгааны хийд

Гантулга: За энэ хийдийн тухай товч мэдээлэл өгнө үү, та? Та өөрийгөө танилцуулна уу?

Чиндэг: За миний нэр Гончиг овогтой Чиндэг гэдэг хүн байгаа юмаа. Одоо наян настай.

Гантулга: Та хэдэн настайдаа Очирдарь хувилгааны хийдэд шавь болсон бэ?

Чиндэг: За би чинь одоо гурван настай байсан юм....

Гантулга: Их л бага байж тиймээ?

Чиндэг: Их бага байсан гэсэн гэж байгаа.

Гантулга: Тэгэхээр хэдэн наснаасаа хэдэн нас хүртлээ хийдэд суусан бэ ...?

Чиндэг: Есөн наснаасаа арван найм, арван есөн нас хүртлээ хийдэд суугаад...тэгээд гадаадад байсан.Тэгээд энэ хоёр багшийн хийдэд орж сууж байгаад...Тэгээд арван есөн настай хар хүн болоод тэгээд цэрэгт гурван жил яваад , Улаанбаатарт ирээд тэрнээсээ хойш явсаар байгаад саяын энэ Маанийн хийд дээр, манай энэ Өмнөговийн анхны хийд байгуулагдахад тэрүүн дээр би оролцож дуганыг нь татаж хурлыг нь хуруулж оролцож явсан хүний нэг ээ.

Гантулга: Тэр бага байхад чинь гадагшаа нүүгээд явчихсан хоёр лам багшийнхаа хийдийн талаар яаж орж байсан товчхон ярьж өгөхгүй юу?

Чиндэг: Энэ хийд бага байсан юм, мэдэхгүй. Тэр Дархан бээлийн хошуунд очиж л байсан юм .Тэр Салаа гэдэг газар л анхан лам нартай, энэ хийдээс гарсан лам нарууд дандаа оргоод дагаад явсан.Дандаа ганц хоёроороо гарсан , тийм улсуудыг цуглуулчихсан.Янз бүрийн хийдүүдээс, энэ Өмнөговийн хоёр Балдан засгийн хошууны хийдүүдээс цуглуулаад тэгээд тэнд анхан хийд нээж. Халхын хийд гэж одоо хаагдчихсан байхгүй шүү дээ.Тэгээд одоо залуу хийд байгаа нь энэ шүү гэж ярьж байсан байгаа юм.Тэгээд тэрнийг залгуулаад явахаар найм ес наснаасаа арван ес хүртлээ залгуулж яваад ирсэн байх гээд байна аа даа, тиймээ.

## МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Гантулга: Аан тийм байна.

Чиндэг: Тэгээд арван есөн настай хар хүн болоод... Тогтоол уншаад, аймаг сумаас хүн ирээд тэгээд зургаахан сар болоод цэрэгт явсан даа.

Гантулга: Тэр Очирдарь гэгээний хийдийг чинь , за Очирдарь гэгээн гэнэ , өөр ямар ямар нэртэй байсан , дээд хийд гээд түрүүн та хэлж байх шиг байсан?

Чиндэг: Аа тэрийг чинь Хошуу хийд ч гэж нэртэй байсан юм гэнэ лээ, дээд хурал ч гэж нэртэй байсан юм байна даа.

Гантулга: Тэд нарынх нь нэрийн учир нь гэвэл, Хошуу хурал гэхээр?

Чиндэг: Аа тэр хошууны л ...Тэр Балдан засгийн хошууны л одоо хамгийн том хийд байсан. Тэрүүгээр нь л нэрлэсэн хэрэг байлгүй дээ. Хошууны том нь л юм болохлоор тэрүүгээр нь тэгж байсан байлгүй дээ, бодвол.

Гантулга: Дээд хурал гэхээр чинь доод хурал энэ тэр гэж бас байх нь ээ, тиймээ?

Чиндэг: Аа тэр Байшинтыг доод хурал гэдэг байсан байлгүй дээ, бодвол.

Гантулга: Тэр Шавруун ламын хийдийг бол юу гэх вэ?

Чиндэг: Шавруун ламыг хийдийг бол Ламын хүрээний хийд л гэдэг юм байсан. Уул нь Байшинтаас бас тасарсан хийд юм гэнэ лээ.

Гантулга: Байшинтын хийдээсээ үү?

Чиндэг: Тийм, тасраад..

Гантулга: Энэ тэгэхээр аль нь ах хийд болох гээд байна?

Чиндэг: Энэ Байшинтын хийдээс тасарсан гэхээр Байшинт нь түрүү байсан байж таарна л даа.

Гантулга: Нөгөө хоёр хийд нь тэгэхээр...?

Чиндэг: Наад хийд нь бол түрүү хийд юм билээ.

Гантулга: Хэдэн онд байгуулагдсан бол?

Чиндэг: За тэрнийг нь мэдэхгүй.

Гантулга: Хэзээ хэн байгуулсан талаар бол...?

Чиндэг: Одоо мэдэхгүй.

Гантулга: Тэр дуганыг, одоо Очирдарь гэгээний хийдийг хуучин засаг захиргааны юугаар яривал Балдан засгийн хошуу, Түшээт хан аймгийн л гэж явах уу?

Чиндэг: Балдан Засгийн хошууны хийд. Аа цөмөөрөө эндээсээ энэ баруун тийшээгээ энэ уулаадаа бол дандаа Балдан Засгийн хошууных байсан юм билээ.Тэр ноён баруун талын хэдэн сумууд чинь бүгд Балдан засгийн хошуу гэж явна.

Гантулга: Тэр газар усных нь нэрийг нэрлэвэл, сүм хийд байж байсан ?

Чиндэг: Одоо энэ Дүнгэнээгий хийд л гэж. Жаргалант л гэдэг юм л даа.

Гантулга: Жаргалант гэж хэлдэг юм үү?

Чиндэг: Тийм, Дүнгэнээгийн хийд...

## МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Гантулга: Тэр Жаргалант гэдэг нь ямар учиртай нэр байх уу?

Чиндэг: Тэр газрын нэр л тийм юм билээ л дээ.

Гантулга: Тэгвэл Жаргалантын хийд гэдэг чинь тэр Дүнгэнээгээ?

Чиндэг: Тийм, нэг л газрын нэр.

Гантулга: Тэр Гүж лам гэж бас зарим хүн нь ярьж байсан ?

Чиндэг: Тийм, Гүж лам гэж байсан юм гэнэ лээ.

Гантулга: Аа тэр Очирдарь ламаасаа өөр үү?

Чиндэг: Өөр өөр. Зарим хүн нь холион бантан хутгадаг юм. Тэр Гэндэндаржаа нэг ном бичсэн байсан. Би тэрнээс харж байсан.Хоёр хүний хорондуур хутгалдсан юм харагдаж байсан. Гүж лам чинь тусгай.

Гантулга: Тэр хийд дээр байсан юм уу, өөр хийд дээр байсан юм уу?

Чиндэг: Тэр харийн Шилүүстэйн хийд дээр байсан юм , тэр сүүлийн үед.

Гантулга: Аа Хүрмэн сумын?

Чиндэг: Тийм, Хүрмэн сумын. Тэр Гүж ламын хийд гэж, тэнд ярьдаг байсан юм гэнэ лээ. Анхан бол Балдан засгийн хошууны ууган хийд нь юм гэнэ лээ л дээ, Хүрмэний хийд.Сүүлд нь тэр Гүж ламтан Хүрмэний хийд дээр байсан юм гэнэ лээ.

Гантулга: Тэгвэл тэр Шилүүстэйн хурлын хүн болох гээд байна, тиймээ?

Чиндэг: Тийм л болох гээд байгаа юм. Одоо юм цуурах аа байсан ш дээ. Аль хэдийн юу болсон юм, мэдэхгүй.

Гантулга: Хийдийн ойр орчимд байгаа одоо тахилгатай уул ус, хад овооны нэр, тийм газрууд бол байсан л байгаа даа?

Чиндэг: Байсан л байлгүй дээ, одоо мэдэхгүй. Одоо Хошуу овоо нэртэй , сая бас тахисан, би очиж сууж байгаад л ирсэн.Дээр үед тахидаг байсан, Хүрмэний яг уулан дотор бий л дээ, Хошуу овоо.

Гантулга: Хошуу...?

Чиндэг: Хошуу овоо.

Гантулга: Хошуу овоо, аа мөн.

Чиндэг: Тэр Балдан засгийн хошууны хошуу овоо, тахидаг овоо байсан юм гэнэ лээ.Тэгээд л энэ баруун талын хийдийнхэн чинь бүгд ирдэг, өөр л хийд байвал асар майхантайгаа ирдэг. Тэгээд нийлж тахидаг , тийм.

Гантулга: Хошуугаараа?

Чиндэг: Хошуугаараа тахидаг тийм овоо байсан юм.Тэгээд сүүлийн нэг жил Балдан засаг ноён нь гэл үү, аль ноён нь гэл ээ, хүнд хүчилтэй холоос ирдэг баруун хэдэн сумуудыг нь гурван тэгс ноён Сэрвэй энэ гурвыг тэндээ ноён богдоо тахиж бай, аа эндээ ойрхон энэ Баяндалай, Хүрмэн энэ сумынхан нь эндээ энэ Хошуугаа тахиж бай.Тэгээд бичиг зарлиг өгөөд тэгээд тасарч тахидаг болсон юм гэнэ лээ, баруун талынх нь наашаа явахаа байгаад , эндхийх нь баруун тийшээ явахаа байгаад.

Гантулга: Аан за.

## МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Чиндэг: Уул нь тэр Ноён богд гэдэг чинь тэр, Жасрай гэгээний л гол л бас тэр Ноён Богдын тодотгосон ламын л ...Тэр нутгаас тодорсон.

Гантулга: Энэ Очир ламын хийдийн ойр орчимд тэр Байшинтын хурал, Овоотын хурал гээд л байна ш дээ тиймээ?

Чиндэг: Тийм.

Гантулга: Өмнөө одоо ойр орчимд байсан байнгын холбоотой хурал хийд гэвэл? Шилүүстэйн хурал орох уу?

Чиндэг: Орно л доо.

Гантулга: Өөр наашаагаа гэхэд одоо?

Чиндэг: Даваад ер нь юм байхгүй байх аа.

Гантулга: Ер нь тэгээд л эргэн тойрныхон нь...?

Чиндэг: Нэг хэсэг юу байлаа. Энд тэнд одоо Дуган голонч гээд л байдаг, Цагаан дашин хийд гээд л энэ тэр түүр байж л байх юм байна лээ л дээ.Төллөж чадахгүй гунж болоод л нэг газар барьчихаад л тэгээд байдаг байсан юм байна лээ л дээ, тэр үед дотроо. Тэгээд нэг жаахан бөөнтүүлээд , энэ өвөр дагуулаад бөөнтүүлээд авсан юм шиг байгаа юм. Хэдэн хийдүүдэд хуваагаад лам нарыг нь .

Гантулга: Урагшаагаа яагаад уу?

Чиндэг: Тийм, уулаа давуулаад...Энэ уулан дотор ч бас ямар юм гэлээ дээ, нэг түүр эн тэр байдаг юм гэнэ лээ. Тэр дуганаас чинь дээшээ Цагаан дашин хийд гээд бас нэг жоохон хөөрхөн түүр байж л байдаг юмаа. Тэрнийг олоогүй юм гэсэн.

Гантулга: Тэр суварга сүүлд босгоход чинь нэг хийдийн суварга байсан гээд та түрүүн ярьж байсан даа?

Чиндэг: Тийм.

Гантулга: Тэрэн дээр та нар аа энд нь нэг ийм юм байсан юм гээд ярьж байсан. Тэгээд тэгж ярьж байхад бол тэнд нь нэг тийм юм байсан юм гээд яривал одоо? Тэр зургийг хараад?

Чиндэг: Тэр зургийг харах юм бол, тэр зураг Баярсайханд байсан юм.

Гантулга: Баярсайхан гишүүнд үү?

Чиндэг: Тийм. Тэрнийг л Баярсайхан гаргаж ирээд л нэг суварга олох гээд л бүгдээрээ харцгаагаад л ...

Гантулга: Тэр хуучных нь эх зураг уу?

Чиндэг: Хуучных нь эх зураг энэ гээд.

Гантулга: Фото зураг уу, гар зураг уу?

Чиндэг: Фото зураг. Яг л энүүн шиг л тэр, саяын хоёр ламын авдаг зураг байна лээ. Тэгээд л тэрийг харцгаагаад л энэ тийм юм байж, тэр тийм юм байж гээд л . Тэгээд л тэд нар чинь бас жоохон жоохон нэртэй байгаа юм чинь , тэр одооны энэ дуган .Тэгэхээр нь арай түрүүнээс нь үзээд бас сангийн бойпор мойпор, ураг мургийн зураг нь тэнд байж байгаад, тэр дугуй ширээ, мирээ нь байсан юм.Тэгээд өнөө Гомбобанчиг гэж нэг одоо юу билээ, тэнд сууж байсан нэг өвгөн, ай харин тэрнээс л асууж нэг дор жаахан юм мэдэж авлаа.Хонь , мич, тахиа, нохой, гахай ер хүрчихсэн хүн байх шив дээ. 85, 86 , 87 , 88, 89 би чинь хоньтой хүн юмдаг.

## МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Гантулга: Энд шавилж сууж байсан хүн юм уу?

Чиндэг: Тийм, энэ Хошуу хийд дээр чинь дандаа шавилж сууж байсан. Харин тэр бол асуух юм бол юм хэлнэ, тэдийд эдийд тиймдацантай байсан, хэдэн ламтай байсан, мэдэх хүн тэр л ганц бий дээ.

Гантулга: Одоо энэ хийд бол шарын шашны хийд байгаа юу?

Чиндэг: Тийм.

Гантулга: Та сахил хүртчихээд одоо энэ хийд нүүгээд явахад үргэлжлүүлээд шавилж суусан хүн юм байна ш дээ, тиймээ?

Чиндэг: Тийм, тэгсэн.

Гантулга: Тэгээд яасан, тэр чинь цогчин уншлага гэж уншчихаад тэгээд дараа нь дацангуудад шилжээд үзээд явдаг ш дээ, бүр нарийвчлаад?

Чиндэг: Өө тэр чинь олон дацан гэх юм байхгүй. Лам нар цөөхөн байсан. Тэгээд мөн нэг Чойртой болоод...анхандаа цогчингоо уншдаг байсан, тэгээд жасаатай байж байгаад сүүлдээ зүүн ч юмуу яваад байсан, тэгээд баруун сүм хүртэл явсан юм чинь тиймээ. Тэгээд тэнд очиж бас нэг Чойртой болоод, бас нэг Чойр гэж ийм юм байдаг юм байна, ингээд босоо...засал хийнэ гэж нэг ийм юм байдаг юм байна гээд бас зах зухаас нь үзэж байгаад сурсан юм байхгүй байж байгаад ирсэн байхгүй юу. Гавжийн дамжаанд нэг сууж үзсэн.

Гантулга: Ямар исчойр байсан

Чиндэг: Би чинь аграмбын дамжаанд чиг л бас нэг сууж басйан. Юм юмыг л маниусд үзүүлэх гэж л байсан юм шиг байна.

Гантулга: Юм юмыг л ?

Чиндэг: Тийм, тэгж л байсан байх. Гавжийн дамжаа, домын дамжаа, аграмбын дамжаа энэ тэрийг бол сууж сууж үзүүлж л байсан юм.

Гантулга: Энд байсан дацан гол дуган эд нар бол яг тэр хэвээрээ бурхан шүтээнтэйгээ явсан уу? Гол шүтээн?

Чиндэг: Гол шүтээн... Гол шүтээн чинь одоо эндээс чинь одоо тэр Гомбо л явж байгаа нь тэр дээ, ер нь .

Гантулга: Ер нь Хошуу хийдийн тэр гол сахиус нь Гомбо?

Чиндэг: Гомбо. Тэр Гомбо сахиус чинь л цуг явсаар байгаад, энэ чинь ямар учиртай ч сүм байсан юм, мэдэхгүй, тэр багад. Энэ хоёр лам, тэр Очир лам залуу хутагт хоёр чинь л маниусыг ном харгүй чухам айл гэртэхээс өөр юм мэдэхгүй байхад, ном зааж гадаадыг үзүүлсэн улс чинь энэ хоёр юм шүү дээ. Одоо энэ хоёрын командад л, одоо энд буулаа гэвэл буугаад л, нүүлээ гэвэл нүүлээд л. Хаа буулгадгийн энэ хоёр чинь л мэдэж явсан улс байхгүй юу, ер нь .

Гантулга: Гол шүтээн нь Гомбо юм байна, тиймээ?

Чиндэг: Гол шүтээн нь Гомбо.

Гантулга: Ядам сахиус гэвэл?

Чиндэг: Өө олон...Жинхэнэ тэгж олон авч явсан сахиус нь байгаагүй байх аа.

Гантулга: Ер нь таныг сахил хүртэж байхад хичнээн ламтай хурал байсан бол, энэ Хошуу хийд?

## МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Чиндэг: Аа мэдэхгүй.

Гантулга: Багцаагаар?

Чиндэг: Ямарх ч байсан нэлээн олон л байдаг байсан. Тэр том...

Гантулга: Гурван зуу. Таван зуу?

Чиндэг: Гурван зуу ч лав байсан.

Гантулга: Сүүлдээ бол их цөөрсөн үү?

Чиндэг: Өө ямар яриа байхав. Хураагдах нь хураагдаад л , тэгээд л оргоод л ...Гэр гэрээрээ аваачаад л зугтаад явчихаар чинь тэгээд...Хаяад л яьцгаачихаар чинь тэгээд , ганц нэгээрээ цуглаад л...Тэр Гомбо сахиусыг чухам ямар оам авсныг нь мэдэхгүй юм, энэ Ширээт...Шоирэв Намхай гэж нэг хар хүн байсан юм, тр би өвөртөлж ирсэн гэж ярьдаг байсан юм.

Гантулга: Энэ Балдан засгийн хошуу гэж явдаг байсан, энэ хошуунаасаа ирж лам нар шавилдаг байсан уу, ойр хавийн хошуунаасаа ирж шавилдаг байсан уу?

Чиндэг: Өө хошуунаасаа л ирэх байх даа.? Явах нь яваад л гадагшаа явж ном үзэх хэсэг нь яваад л , ирж суурьших нь , суух нь суугаад л. Гадагшаанаас нэг ачаа ачаад л морь унаад ирсэн нь цөөхөн юм , тэгээд л явган л тэгээд л ирдэг юм.

Гантулга: Хувилгаан лам нь бол хийд дээрээ байсан уу?

Чиндэг: Хийд дээрээ л байсан.

Гантулга: Өөр одоо том хутагт хувилгаан гэгээн...?

Чиндэг: Тийм хүмүүс байгаагүй .

Гантулга: Унзад , цорж , гэсгүй...?

Чиндэг: Өө тэр байлгүй яахав , тэр чинь хийдтэй газар болгонд байлгүй. Хэн нь хамаагүй тушаагаад гаргачих юм чинь тэр болно гэсэн үг.

Гантулга: Аль нэгээс нь нэрлэвэл?

Чиндэг: За чи унзад сууна аа гэвэл, жас л гэнэ, за чи гэсгүй сууна аа гэвэл жа л гэнэ. Би үгүй ээ, би чадахгүй ээ, би дийлэхгүй юм байна гэвэл тэр өршөөл байхгүй. Ямар юм байхав дээ, тийм юм байхгүй.

Гантулга: Хүрээнээс ч юмуу, том Төвд, энэ жас масаас ч юмуу Төвд багш нар ирж хичээл заадаг байсан уу?

Чиндэг: Тэрийг ерөөсөө мэдэхгүй юм.

Гантулга: Гэлэн сахилтай хүн бол олон байсан уу?

Чиндэг: Өө тэр гэсгүй зөндөө, тэр байдаг л байсан.

Гантулга: Том том нэртэй зурхайч маарамба?

Чиндэг: Аа тэр зурхайч нар олон байсан.

Гантулга: Эмч?

Чиндэг: Тийм, эмч зурхайч нар олон байсан даа.

Гантулга: Уран, бурханч?

## МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Чиндэг: Аа тийм, зурдаг хүмүүс зөндөө байсан. Ямар ямар улсууд байсан юм мэдэхгүй.

Гантулга: Жишээлбэл одоо ямар ямар эмч, зурхайч хүмүүс байсан бэ?

Чиндэг: Одоо Зундуйдорж гэж ,цорж Зундуйдорж одоо чиний хэлснээр тийм сүрхий хүн , хэнд ч гүйцэгддэггүй зурхай зурдаг лам байсан юм гэнэ лээ.

Гантулга: Хошуу хурал дээр?

Чиндэг: Тийм, Хошуу хурал дээр.

Гантулга: Хичнээн дугантай , хичнээн дацантай , жастай...?

Чиндэг: Аа тэрнийг бол яг мэдэхгүй юм.

Гантулга: Сүүлд ийшээ гарахаар цөөрчихсөн болохоор тэгээд бөөндөө л нэг?

Чиндэг: Тийм, бөөндөө л нэг.

Гантулга: Ер нь энэ Хошуу хийд, Байшинтын хийд эд нар ямар исчаатай байсан бэ?

Чиндэг:Мэдэхгүй юм даа, одоо энэ чинь домын дамжаа барьдаг суудаг, гавжийн дамжаа барьдаг байсан болохлээр одоо Гомон дацангийн дэгтэй, юутай л байсан байх таараа даа.

Гантулга: Тэр хуучин суварга босгосон, тэр хуучин суварга байж дээ , тиймээ?

Чиндэг: Байсан. Тэр бүр байсан буурь нь байна лээ. Тэр Баярсайхан гишүүнд л бий, тэр зураг нь одоо, үзье гэвэл.Тэрний ах нь байгаа юм , тэр миний хэлээд байгаа.Одоо ер хүр я байгаа юм .Тэгээд тэр ноднин авчраагүй байсан .Үгүй ээ та нар чинь яагаад Омбоогоо авчраагүй юм бэ гээд би бас тэгж л байсан.Энийг чинь мэдхээр хүн ганц л тэр байна ш дээ, одоо ...тэгж байсан юм. Энэ хавар бий сурагтай байсан. Бий байх аа, одоо жоохон харвах дөхчихсөн.Гайгүй л дуулдаж байсан.

Гантулга: Тэр дацан сүм дуган чинь тус тусдаа нэртэй байсан уу?

Чиндэг: Тус тусдаа нэртэй байлгүй.

Гантулга: Нэр устай ...?

Чиндэг: Тэр цогчин дуган, Чойрын дуган, Мамба дацангийн дуган гээд тус тусдаа нэртэй, тус тусдаа жастай байсан.

Гантулга: Тийм л байх даа тиймээ, номын бар, бар хийх үү?

Чиндэг: Тэр их байсан, нөхцөл байхгүй.

Гантулга: Тэр үед одоо нийтэд нь тэр хийдийн Төвд нэрийг юу гэдэг байсан бэ?

Чиндэг: Мэдэхгүй.

Гантулга: Байшинтын хийдийг? Одоо Гандантэгчинлэн гэдэг ч юмуу?

Чиндэг: Тийм, Гандантэгчинлэн...Тэрийг нь мэдэхгүй.

Гантулга: Хийдэд тэр дацандаа юм уу, цогчиндоо хурдаг хурал ном гэвэл, цогчин уншлага юм уу?

Чиндэг: Өө тийм, цогчиндоо л одоо...Хаа газрын хийд цогчингоосоо л эхэлдэг байсан байна л даа. Хамгийн урдаар, тэгээд сүүл рүүгээ байж байгаад тасраад тасраад сүүл рүүгээ янз янзын төрөл төрлийг номыг нь үзэж

## МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

байгаад тэгээд тасараа сүм хийдээ барьж байгауулаад, ламынхаа хуваарийг гаргадаг ,ийм байсан бололтой юм.

Гантулга: Цогчин уншлага чинь одоо хийд бүрд өөр өөр байна аа, тиймээ?

Чиндэг: Өөр өөр байна аа.

Гантулга: Ямар цогчин уншлагатай байсан.

Чиндэг: Тэр газар газрын ард түмний оруулж уншдаг, уншдаггүй тийм янз бүрийн л ...

Гантулга: Тэр оруулж уншдаг номноосоо л болох уу?

Чиндэг: Тэгнэ.

Гантулга: Сар бүрийн одоо хурал, шинийн найман, арван таван?

Чиндэг: Аа тэр бол...цогчин гэдэг бол өдөрт дуусдаг хурлын нэг, тэр цогчин жасаа хоёр бол. Ямар сахиустай юм, тэр Гомбо юмуу, Чухам юм уу тэрнийгээ тахидаг. Жасааны лам тусдаа гээд нэг цан барьчихсан хүн тэгээд л сууж л байдаг.

Гантулга: Жилд болдог том хурлын нэг гэвэл Цагаан сарын хурал байна?

Чиндэг: Аа тэр чинь өвлийн том хурал, зуны хурал гээд ...хайлан. Аа тэгээд Чойртой газар бол Чойр, хаврын Чойр. намрын Чойр гээд тэгээд явна л даа.

Гантулга: Цам гардаг байсан юм болов уу?

Чиндэг: Цам гардаг байсан юм байлгүй дээ. Би ёстой мэдэхгүй юм. Аа лав л Байшинт дээр гардаг байсан .Равжаа гэж нэг ,зайлуул нас барсан даа, намайг жаахан байхад, аравтай байхад,тэр хүн цамд цамнасныг үзэж байсан , анхан би.жоохон юм л , дүрсгүй, мэдэхгүй байсан юм чинь.Тэгээд тэр Байшинтын хийд дээр цамыг цамнадаг хүн байсан юм гэнэ лээ. Тэгээд тэнд очиж анхан нэг цамыг цамлахыг үзсэн юм байгаа юм.

Гантулга: Равжаа гэж нэг зурхайч хүн байсан уу?

Чиндэг: Үгүй ээ.

Гантулга: Цагаан толгойтой өвгөн байсан уу?

Чиндэг: Нэг өндөр, өндөр цагаан толгойтой өвгөн байсан юм. Тэр чинь биерхүү настай хүн байсан. Жар хүрчихээд цамыг цамнаж байсан хүн байсан хүн байгаа юм.

Гантулга: Майдар эргэнэ, ганжуур эргэнэ?

Чиндэг: Аа тийм , эргэнэ. Тийм юм байсан байлгүй дээ.

Гантулга: Сор залдаг байсан байлгүй дээ?

Чиндэг. Аан ...цорж?

Гантулга: Сор?

Чиндэг: Аан сор залалгүй дээ. Сор залахаар чинь л тэр шамир цамнаад л дагаад явж байдаг байсан юм байгаа юм. Том лам нар ч яахав тэгээд л шам цамнаад үгүй бол явахаар нь л дагаад л явж байдаг байдаг, цамнаад л .Тэгээд л явж байдаг байсан байгаа юм, энэ хэдэн лам нар чинь

Гантулга: Хошуу хурал байсан болохоор хошуугаа тойрдог байсан байх даа , энэ ганжуур нь ?

## МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Чиндэг: Тийм ,тэгдэг байсан. Ямар машин байх биш дээ, хэдэн тэмээ ачаад л улаан юмаар ачаад л , улаан юмаа тэмээндээ ачаад л хэдэн хүмүүс тойроод л эргэж байдаг байсан юм гэнэ лээ, ганжуураа.

Гантулга: Олон лам оролцдог байсан байх даа , бодвол?

Чиндэг: Тийм, цөөхөн байсан байлгүй. Тэр буусан газраа ...

Гантулга: Тэмээнд ачаад л ?

Чиндэг: Тэмээнд ачаад л , тэгээд л нэг зул өргөдөг, тахил өргөдөг .Өглөө орой тэгдэг л байсан байлгүй.

Гантулга: Цагаан сарын хурлаар яг одоо өвлийн адаг сарын тэднээс эхлээд л ямар ямар ном уншина гээд л ?

Чиндэг: Тэр чинь одоо өвлийн адаг сарын хорин гурванд наранжанлив хийчихээд л тэгээд л долоон хоног хурж байж байгаад, хорин есөнд Чойжил хураад сороо залчихаад, битүүнд өдөр нэг мацаг барьж байгаад...Цогчин, цогчингоо яахав дээ, хүүхдүүд өдөр хурдгаа хурчихна. Тэгээд битүүн шийнийн шөнө цуглаад ламаа яамалчихдаг. Номоо хурчихдаг, тийм л байсан. Тэгээд л цагаан сарын үүрээр л хэдэр гадаалуулна гээд л , өвлийн цагт чинь хөлдөөж алчих гээд л / инээв/. Чичрүүлээд л , гадаа гаргаад л , тэгээд зуунгатчихна. Тэгээд хэдэр гадаалчихаад л орж ирдэг байсан.

Гантулга: Бурхан багшийн дүйчэн өдрөөр хурдаг хурал?

Чиндэг: Хурна аа. Тэр чинь магтаал л хурчихдаг байсан.Дүйчэн өдөр болгон магтаал л .

Гантулга: Богд ламын дүйчэн өдрөөр?

Чиндэг: Богд ламынхаар ч тэр, ямар л дүйчэн өдөр , дандаа магтаал ерөөл л.

Гантулга: Хайлан хурдаг байсан уу?

Чиндэг: Хайлан хурна аа.

Гантулга: Олон ламтай?

Чиндэг: Одоо яахав дээ, нэг гучаад...гучаад энэ тэр лам суучихдаг л байсан байх.

Гантулга:Голцож гэлэн сахилтай байх уу?

Чиндэг: Гэлэн гэцэл холилдоод л суучихна, ердөө.

Гантулга: Нүгнээ тахидаг байсан уу?

Чиндэг: Нүгнээ сахина аа .Цагаан сарын шинийн нэгнээс эхлээд л нэг хэдэн лам нар л нүгнээ сахиж байгаа нь энэ гээд л...

Гантулга: Аа тусдаа?

Чиндэг: Тийм , тусдаа нэг дугантай, сахичихдаг.

Гантулга: Жилдээ ганц л удаа сахих уу, хамаагүй юу?

Чиндэг: Аа зөндөө. Цагаан сарын сар, энэ хайлангийн сар, энэ дүйчэн өдрөөр чин дандаа нүгнээ сахиатай байдаг байсан, лам нар.

Гантулга: Цагаан сарын тэр арван тавнаар уншлага ямар уншлага байх уу, магтаалаа л унших уу?

Чиндэг: Магтаалаа л уншина.

Гантулга: Арван тав хоног?

## МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Чиндэг: Арван тав хоног.

Гантулга: Овоо тахих ч юмүү, тийм үеэр наадам их хийж баярладаг байсан уу?

Чигдэн: Өө наадам даншиг их хийлгүй дээ. Наадам зөндөө хийдэг байсан , зун нь.

Одоотой адил өвлийн морь уралдаан, тэмээн уралдаан гэж л тэгдэггүй байсан ./инээв/

Гантулга: Овоо тахих ,эсвэл?

Чиндэг: Өө овоо тахих гэж нэг их юм болдоогүй байсан. Бид нар чинь нүүдлийн улс, хаана юу байгаагийн нь яаж тахих вэ дээ, байхгүй л дээ.

Гантулга: Наадам хийдэг том хурал гэвэл?

Чиндэг: Наадам хийнэ ээ. Жанчив манчив гээд...

Гантулга: Жанчив?

Чиндэг: Жанчив хийнэ л дээ. Тэр майдар эргэхээр жанчив...Хайлан тэнхлээ.

Гантулга: Майдар эргэхэд майдрын цам гэж гардаг байсан болов уу?

Чиндэг: Аа тэр ногоон морин толгойтой , юутой морин толгойтой юмнууд явдаг л байсан л даа.Олон тал талд нь очиж үдлээд л ...

Гантулга: Одоо ингээд Чойр дацан , Жүд гээд л жоохон жоохон үзүүлэн гэж байна. Тэр дацангийн тусгай өдрийн уншлага гэж байх уу?

Чиндэг: Байсан байлгүй. Одоо тэр Чойрын Шагжин гэж байгаа биз дээ, одоо...Тэрийг чинь л одоо өдөрт уншдаг байсан.

Гантулга: Сарын хурал , жилийн хурал?

Чиндэг: Тийм...Шагжин гэж юм уншина, Чойр дацандаа.Цогчин дацандаа цогчин уншина

Гантулга: Дүйнхор дацан гэж байсан уу?

Чиндэг: Дүйнхор оо...Дүйнхор цөөхөн лам нар хурж байсан.Хурдаг байсан, бүр хачтан хийлцдэг байсан, тэр хуралд.Тэр чинь хэдхэн нэртэй цөөхөн лам нар.: тийм номоо тэндээ л хурна. маниусд бол ер нь үзүүлэх гэж л байснаас, нүүдлийн юманд тогтмол юу байхав.

Гантулга: Энэ одоо дацан дуганых нь хийсэн барилгын материал гэвэл

Чиндэг: Тийм...нүүдлийн том ханатай.

Гантулга: Аа нүүж явахад тийм...?

Чиндэг: Тийм, ингээд дээшээ доошоо болгодог. Томсож болдог, ханаа нэмээд, баганаа нэмээд л ,униа нэмээд тэгээд томсоод явчихдаг. Тийм юутай.

Гантулга: Аа мөн мөн. Нүүдлийн маягийн?

Чиндэг: Тийм, нүүдлийн маягийн.

Гантулга: Гэр дуганархуу?

Чиндэг: Тийм, тэгээд дөрвөлжин.

Гантулга: Дөрвөлжин, тэгээд эсгий...?

## МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Чиндэг: Дотроо ингээд нөгөө нэг яагаав дээ , одоо...

Гантулга: Цогчин дуганы юу?

Чиндэг: Тийм, бортхаан гэж...Тэрний маягтай дуган байгаа л , хийх гэж байсан юм. Тийм дарвөлжин, дээшээ доошоо болдог уньтай, тийм тэлүүртэй. Томссон ч болдог, багассан ч болдог.Тийм дугантай байсан юм.

Гантулга: Хуучин энэ суурин дээрээ нүүж суудаггүй байхдаа болвол нэлээн тийм Хятад, Төвд маягийн байшингуудтай байсан байлгүй?

Чиндэг: Үгүй. Байшин байгаагүй. Дандаа гэр.

Гантулга: Тийм байсан уу?

Чиндэг: Дандаа гэр.

Гантулга: Тэр нэг шавар гэр мэр, байшингийн ормууд?

Чиндэг: Одоо энэ хийдүүд байгаа байлгүй дээ. Гэртэй ч байсан, байшинтай ч байсан.

Гантулга: Хошуу хийд?

Чиндэг: Тэр байшин цоройтой юм билээ. Цоройг нь харахад...Тэдний хашаа, эдний хашаа энэ тэр гэж ярьдаг.

Гантулга: Одоо тэр Чойр гэхэд чинь , Чойрын дацан гэхэд чинь шүүлэг дамжаа байна уу?

Чиндэг: Өө тэгэлгүй яахав. Шүүлэг авчихна. Чойрт шүүлэг өгнө, үгүй хааяа наад зах нь шүүлэг өгч байж орно ш дээ.

Гантулга: Домын дамжа барихад бол яах уу?

Чиндэг: Домын дамжаа ч ялгаа байхгүй л дээ.....юу хүрээд л домын дамжаанд сууна л даа.

Гантулга: Гавжийн дамжаа?

Чиндэг: Гавжийн дамжаа ч яахав дээ , энэ жил л нэг хэдэн лам нарт...за хойтон жил бас нэг хагас хугас хэдэн лам нарт...

Гантулга: Тушаачихна?

Чиндэг: Тушаачихна.Тэгээд л номоо үз ээ, юмаа мэд ээ.Тэгээд л нөгөө аштай хэдэн улсууд нь номоо үзээд л .....

Гантулга: Тэр дамжаа барих чинь хугацаатай биз?

Чиндэг: Хугацаатай. Жилийн хугацаа.Жил болоход л юмаа бэлдэнэ, орох юмаа бэлдэнэ.Номоо бэлдэнэ, тур улсууд.

Гантулга: Зийрэмбийн дамжаа, маарамбын дамжаа гэж бас байсан уу?

Чиндэг: Тийм, яг тэгдэг байсан л даа. Маарамбын дамжаа ч гэж нэг их олон амьтан, сүрхий ламтай байгаагүй байх.Зүгээр маарамба нар гээд улсууд эм барьдаг.

Гантулга: Нэг удаа дамжаа барихад бол ламынхаа тооноос л болох уу, олон цөөн гээд л ?

Чиндэг: Тэгнэ.

Гантулга: Олон ламтай бол олон хоног гээд л ?

Чиндэг: Тэгнэ.

## МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Гантулга: Гүнчин ишчойр байсан гэж байгаа , чойр нь бол тиймээ?

Чиндэг: Тийм л байх даа...

Гантулга: Гомон ишчойр?

Чиндэг: Гомон дацангийн гомон ишчойр л байх даа.

Гантулга: Олон жисаа байдаг байсан уу, ер нь таныг байдаг байхад?

Чиндэг: Үгүй энэ чинь яахав дээ. Доод зиндаанд бол хүүхдүүдийг хуваарилаад тавьдаг байсан. Адаг шүдээсээ авахуулаад л дунанжав хүртэл тэгээд л байсан даа. Дээшээ том болоод явчихлээр нөгөө гаарамба гээд гараад явчихна л даа.Өнөө дунаж энэ тэр гэд явчихна. Тэгээд тэндээсээ нөгөө гавж болох хүмүүс энэ тэрээ тушаалдана.

Гантулга: Өөр Хошуу хийд бол том том хийдүүдтэй лам солилцох , ном хаялцах ч юмуу тийм юм байсан уу?

Чиндэг: Тийм юм ч ер нь намайг жоохон байхад байгаагүй ээ.

Гантулга: Очиж дамжаа судаг ч юмуу, эсвэл ном хаялцах?

Чиндэг: Тийм юм энэ нутагтаа байхад бол бишгүй л байсан юм гэнэ лээ. Номгоноор ороогүй байгаа биз дээ?

Гантулга: Ороогүй.

Гантулга: Хүрмэн , Номгон гээд одоо ингэж л явж таарна даа.

Гантулга: Нутагтаа байхад бол энэ Хүрмэн Номгоны хийдүүдээр...?

Чиндэг: Өө энэ нутгийн хийдүүдээр хэсээд л , дамжаанд сууцгаачихдаг. Цагийн хуралд очоод сууцгаачихдаг байсан юм гэнэ лээ.

Гантулга: Баруун Халхын энэ баруун зуугийн хурлуудтай бол холбоо харилцаа?

Чиндэг:Тэрийг одоо хэн мэдэхэв. Тэнд одоо очиж суусан суудаг лам нар зөндөө л байсан юм гэнэ лээ.

Гантулга: Мөргөл энэ тэр хийж..?

Чиндэг: Яасныг нь мэдэхгүй, тэгээд л алдчихдаг. Тэр өчнөөн жилийн дараа л сураг нь гарч байдаг.

Гантулга: Хичнээн жастай хуралд байсан юм , энэ Хошуу хурал?

Чиндэг: Мэдэхгүй.

Гантулга: мэдэхгүй юу?

Чиндэг: Хийдийнхээ юугаар л , дацангийхаа юугаар л жасай байна л даа, тэр чинь.

Гантулга: Жас, жасын мал бол олонтой л байсан байх даа?

Чиндэг: Аа тийм. Тэгээд л жасын мал малладаг айл гээд ядуухан шиг айл маллдаг байсан юм гэнэ лээ, шан хөлсийг нь өгөөд. Жилд л нэг тамгалж байгаа нь энэ гээд л нярав тамгаа аваад л морь , бичээчтэйгээ явдаг байсан юм гэж л ярьдаг байсан.

Гантулга: Одоо энэ хүрээ хийдүүд энэ тэр бол , Хошууны тамгын газар энэ тэр татвар хөлсийг нь төлдөг байсан уу?

Чиндэг: Аа хошуу төлдөггүй байсан.

Гантулга: Төлдөггүй байсан уу?

Чиндэг: Юу л төлдөг байгаа аж.

## МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Гантулга: Лам нар бол одоо голдож л гэрт суух уу, орон сууц нь бас шавар байшин эд нар байх уу?

Чиндэг: Өө тэгээд л зарим нь модон байшин, шавар байшин гээд л ...Тэр өөрснөө хүний чадлаараа л байдаг юм.

Гантулга: Ер нь нийтлэгээрээ бол гэр?

Чиндэг: Гэр л .Би тэр байшин барьж байшинд сууж байхыг мэдэхгүй юм бинь, багад.

Гантулга: Тийм дээ, жоохон байсан?

Чиндэг: Жоохон байсан.

Гантулга: Одоо энэ заримс газрууд чинь нөгөө хандмаа, цож, лүйжин гээд?

Чиндэг: Аа бас лүйжин тавьдаг улсууд бас байсан. Тэр хандмаа эд нар чинь байгаагүй ээ, би мэдэхгүй.

Гантулга: Хийдтэй бол ямар ч холбоогүй, зүгээр бараадаад л ойрхон л?

Чиндэг: Тийм. Тэр хийдийн лам нараас чинь лүйжин тавьдаг нь тавина.

Гантулга: Аа өөрсдөө бас?

Чиндэг: Өөрснөө, өөрснөө бас байхгүй.Энэ чинь тэр нь цөөхөн л дөө. Лүйжин тавьдаг лам нар цөөхөн.

Гантулга: Банди байхад чинь одоо нэг бүтэн өдөр байлаа гэхэд , өглөө босоод л одоо ямар зан үйл хийх үү?

Чиндэг: Одоо завгүй л болдог байсан байх юм даа.

Гантулга: Тэгээд?

Чиндэг: Номоо үзнэ. Домноно.Усаа үүрнэ. Түлээ түүнэ. Бүх л гэрийхээ одоо хоол унд бүх л юмаа хийнэ. Өглөө босоод л одоо галаа өрдөөд л , цайгаа юүлээд л , зулаа өргөөд л , тахилаа сэргээгээд л ...Тэгээд л аахилж ирнэ.Тэгэнгээ одоо өнөө хэдэн бичиг цаас байдаг юм уу, завсар нь өнөөхийгөө харна. Тэгээд өнөөхийг чинь дандаа тогтоохгүй ээ, нөгөөх чинь.

Гантулга:Банди байхдаа тэгнэ. Тэгээд нэлээн номоо үзээд ирэхээрээ бас биеэ даах уу, багшаасаа тусдаа амьдарч энэ тэр?

Чиндэг: Өө даалгүй дээ, тэр чинь одоо. Өдөрт очиж багшдаа тусалж , бараалхаж номоо хэмжүүлчихээд л .Тэгээд л номоо үзээд л...

Гантулга:Сүсэгтнүүдэд аврал гүрэм унших ч юмуу, ном уншиж сан тавих тийм юм их хийх үү?

Чиндэг: Тийм юм их гайгүй байсан шиг байгаа юм.Хүн нас барахад л нэг жандаг ирж байдаг тэгээд ерөөл уншина. Нэг их тийм юм дуугараад байдаггүй байсан.Одоотой адил нэг гүрэм задлаад л , Сундуй уншаад л , нэг их олон гүрэм уншаад л ...Ийм юм их хийдэггүй байсан. Гайгүй сайн байвал нэг нэгдэлд очоод , за маных тэдэн хүнтэй, тэдэн хошуу малтай мэнд яваарай, илийн мэнд яваарай. За нэг Сундуй айлдуулчих,малаа төллөхөөс наана Алтангэрэл айлтуулаад даллага авахуулчих ингээд л олон өшөө ч юм хэлдэггүй л байсан шиг санагдах юм.

Гантулга: Хийдийн ойр одоо энэ хар ажил хийдэг, борчуулын хороолол гэж байх үү?

Чиндэг: Үгүй, цанч нар гэж нэг харчуул байдаг байсан юм.

Гантулга: Цанч нар аа?

Чиндэг: Тийм. Тогоо барьдаг, түлээ ч түүдэг, ус авч өгдөг тийм цанч нэртэй.

## МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Гантулга: Цөөхөөн тийм айл байх уу?

Чиндэг: Цөөхөөн , ганц хоёрхон айл байна. Нэг хоёр зэргийн л харчуул байдаг байсан. Тэгж олон хороолол хүрэх юм байхгүй. Ядуухан шиг жоохоон, гүндүүхэн шүү улсууд ганц хоёр байдаг байсан.

Гантулга: Сүсэгтнүүд одоо ингээд хүрэн дээр удаан байгаад эргэл мөргөл хийгээд биеэ эмчлүүлэх тийм юм байх уу, ер нь? Дор дороо л буцах уу?

Чиндэг: Ганжуур зална даа. Ганжур залахад манай хийд дүүрээд л явчихна даа.

Гантулга: Хийдийн ойролцоо одоо худалдаа наймааны газар, Хятадын худалдаа ч юмуу, гар урчууд?

Чиндэг: Тийм юм байхгүй.

Гантулга: Арилжаа наймаа бол байхгүй?

Чиндэг: Тийм юм бол байхгүй.

Гантулга: Ерөөсөө ирдэггүй, та хэзээ хар болсон бэ? Хийдээсээ юу яагаад , хэдэн настайдаа? Наашаа орж ирээд юу яасан уу?

Чиндэг: Би ч одоо арван естэй хар болсон хүн. Тэгээд хар хүн болчихоод , зургаан сард нь , тэгээд зургаан сар дөнгөж гараад л цэрэгт татагдчихсан.

Гантулга: Тэгээд л цаашаа хил орж ирэнгүүт л сүм хийд чинь ерөөсөө тэгээд шууд хаагдчихсан ?

Чиндэг: Аа тэгээд нэг жил...тэгээд байсан. Сүүлд нь тэр Ганданд очоод нийлүүсэн. Тэгр Нүдэнгийн, Айраг сумын Нүдэнгийн хурал гэж байсан. Айраг суманд байсан. За Эрхэт сум нь хоёр тасарсан л юм байх, аргагүй олон улс орж ирсэн. Тэгээд сум суманд хэсэг хэсгээр нь ингээд хуваачихсан юм чинь.

Гантулга: Тэгээд та Айраг суманд нь байсан юм уу, тиймээ?

Чиндэг: Би тэр Эрхэт суманд нь байсан юм.

Гантулга: Нүүдлийн хурал мурал бол бүгд тэр Ганданд ороод явчихсан юм байна, тиймээ?

Чиндэг: Аа тэр тэгээд л сүүлд нь арван жил удаж байгаад л , Бүрд...Бүрдийг хураачихсан байхгүй юу . Хоёр хийдийг чинь, хөдөөний хурлуудыг чинь. Миний мэдэж байгаагаар тэр Айраг суманд нэг хурал байсан, Эрхэтэд нэг хурал байсан . Тэгээд Ганданд очъё гэсэн лам нартай нь очихгүй гэсэнгүй тэгээд хэрэгтэй гэсэн бүх бурхан тэр номыг нь хурааж аваад Ганданд аваачихсан чинь...

Гантулга: Тэр хоёр хурал гэж байна. Нэг нь бол энэ Хошуу хурлын л гол юм яваад байна ш дээ, тиймээ?

Чиндэг: Тийм.

Гантулга: Нөгөө дэх нь аль хийдийн юм явж байсан юм.?

Чиндэг: Тэр юу... Одоо энэ зүүний нэг хошуу байна. Одоо Түшээ гүний хошуу гэж ярьдаг даа.

Гантулга: Говь Түшээ гүний, аа тийм ?

Чиндэг: Говь Түшээ гүний. Тэр талын хийдийн юмнууд л .Бас л олон газрын юм нийлсэн. Өршөө лам гэж байсан юм аа...

Гантулга: Хутагт Өршөө гээд?

Чиндэг: Тийм.

## МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Гантулга: Хамгийн хийдийн лам байсан ш дээ?

Чиндэг: Үгүй ээ, энэ Цэцийн хийд.

Гантулга: Аан Цэцийн хийд үү

Чиндэг: Энэ чигийн лам байсан. Энэ одоо энэ зүүнтэйгүүр чинь олон хийд яриад байгаа ш дээ. Та нар явж үзнэ биз дээ.

Гантулга: Тийм, тийм.

Чиндэг: Тусын гурван хийд гээд л...Тал талын хийдүүд

Гантулга: Одоо тэрүүгээр чинь баахан явна.

Чиндэг: Одоо тэгээд л Суварганы ххийд, юу юу билээ. Их олон сүм бий тэр чинь/ ярилцлага түр завсарлав/ ...Тэр уг нь бас арай нэг хоёр гурван насаар илүү юм байгаа юм, арай илүү юм мэдэх юм. Даанч одоо би мэдэхгүй.

Гантулга: Хийд хаагдах үед бол шүтээн бурхныг нь бүгдийг нь Гандан руу аваад явчихсан байна, тиймээ?

Чиндэг: Тэгсэн.

Гантулга: Өөрсдийнхөө гэр орондоо авч үлдсэн тийм юмаа бас?

Чиндэг: Өө тэр ч овоо тэгж холилдуулаагүй, тэгээд аваад үлдсэн, хоцорсон.

Гантулга: Аваад үлдэх үү?

Чиндэг: Аваад үлдсэн.

Гантулга: Та ч хийд хаагдангуут цэрэгт дайчлагдаад явсан хүн байна ш дээ, тиймээ?

Чиндэг: Хаагдахаас өмнө.Цэрэгт явж ирээд, тэднүүсыг явахад би ачааг нь ачилцаж байсан юм. Мандал өргөөд, дугандаа очиж мандал өргөөд тэгээд машинд ачиж өгөөд...

Гантулга: Тэгээд хар болоод ...?

Чиндэг: Солонгэндэн, Галаагарьд хоёр...Солонгэндэн, Галаагарьд, Гамбаа хэдэн лам нар ирж тэгээд бүх юмыг нь дансалж аваад авахаа аваад, орхихыг нь орхиод Цогт гэж нэг өвгөн жолооч байсан даа. Тэд нар ачаад тэгээд явж байсан юм гэнэ лээ. Би машинд нь ачилцаж өгчихөөд явж байсан юм.

Гантулга: Тэр Галаагарьд гэдэг чинь ямар хүн бэ?

Чиндэг: Аан?

Гантулга: Галаагарьд? Лам хүн байсан үү?

Чиндэг: Лам хүн байсан.Сайн гэвш байсан ш дээ.Тийм, сайн гэвш хүн байсан ш дээ.

Гантулга: Аль хийд дээр сууж байсан юм?

Чиндэг: Хошууны, Хошууны хийд дээр л сууж байсан.

Гантулга: Гандан дээр одоо лам болсон, лам байсан хөгшчүүлтэйгэ хааяа уулзаж ном бас яана биз? Зиндааны тийм тэр хөгшчүүлтэйгээ?

Чиндэг: Би бол одоо тийм юм байхгүй.

Гантулга: Өөрөө бол эндээ гэртээ номоо үзэж харж бас..?

## МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Чиндэг: Би чинь үзэж байсан юм бол ердөө байхгүй.

Гантулга: Тиймүү, бүр ор тас?

Чиндэг: Бүр ор тас хаячихсан. Анхан одоо хүн амьтан асуухад чиг зарим номоо бүр хэлж чадахаа байчихсан байгаа юм. Байхгүй, мартчихсан. Зарим номоо одоо хэлж болохгүй, унших байтугай.

Гантулга: Одоо танаас гадна хоёр хөгшин байга юм байна, тиймээ?

Чиндэг: Тийм.

Гантулга: Цэнджав...?

Чиндэг: Цэнджав, Зандийгэлэн.

Гантулга: Ерэн онд бол энэ Манийн хийд дээр эргээд хурлаа нээсэн юм байна ш дээ, тиймээ?

Чиндэг: Тэгсэн юм.

Гантулга: Ер нь Өмнөговийн хийдүүдийн бүх үлдсэн улсууд л энэ дээр...?

Чиндэг: Тэгсэн юм, тэгсэн юм.

Гантулга: Одоо энэ аймгийн төв дээр ирчихээд байгаа чинь энэ хийдийн юу юм байна, тиймээ?

Чиндэг: Тийм юм.

Гантулга: Одоо энэ аймгийн төв дээр тэгээд хурлаа хураад л ?

Чиндэг: Одоо энэ үлдсэн гурван муу өвгөн чинь гурвуулаа Балдан засгийн хошууны гурван муу өвгөн байгаа юм даа.

Гантулга: Өөр залуу улсууд байгаа юу?

Чиндэг: Залуу улсууд ч яахав дээ. Сүүлийн үеийн залуучуул тэр бол тэндээ тэгээд ямар юм мэдэхэв.

Гантулга: Тэр одоо Байшинтын хийд , одоо энэ Шилүүстэй хийд , тэр Шавруун ламын хийдийн талаар та одоо өөрийнхөө мэдэх юмнаасаа дурсамж болгож яриач? Тэдэн ламтай байсан, тийм жастай...?

Чиндэг:/инээв/ Би ерөөсөө мэдэх юм байхгүй, энд.

Гантулга: Дуулсан юм байна уу, одоо үүх түүхээс нь ?

Чиндэг: Дуулсан юм ч...

Гантулга: Ийм утгатай юм , эд нар чинь ийм холбоотой юм энэ тэр гээд

Чиндэг: Би харин сүүлд мэдээ орсон хожуу бол энэ хоёр ламын яаж байсан, тэр дэгэнд байсан юм болохлээр, ойд...Энэ ламыг болвол мангайд буудаг байсан юм. Илүү тугдам байхгүй. Очирдарь ламын тугдам гээд нэг бий. Тэгээд нааш цаашаа явуут лам л байсан юм.

Гантулга: Аан Жил хутагт уу?

Чиндэг: Тийм.

Гантулга: Очирдарь лам бол өөрөө тугдамтай?

Чиндэг: Өөрөө тугдамтай, өөрөө сантай. Тэндээс ирэхдээ одоо хоол унд бүх юмыг нь тусгай хүн хийж өгнө. Би ядахдээр тэгээд манай тэр томчууд, миний багш тэд нар хоёр гурван том , нэг муу илүү хар гэрт унтуулсан.

## МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Тэгээд ямар хөнжил байсан биш дээ, нэг үстэй дээлэрхүү юм аваад орчихдог. Тэгээд л би өглөө орой гэрээ шүүрддэг, тахил хийдэг, хоол унд авчраад өгөхөөр өнөөхөс нь үлдэхлээр идчихдэг.Тэгээд л /инээв/

Гантулга: Таны багш чинь Ядам унзад гэсэн үү?

Чиндэг: Тийм.

Гантулга: Ядам...Ядамсүрэн.Аа Ядамжав?

Чиндэг: Ядамсүрэн гэдэг чинь сүүлийн үеийн унзад.Гандангийн.

Гантулга: Аа зөв зөв . Ганданд хурж байсан уу, таны багш?

Чиндэг: Хурж байгаад , тэгээд унзад хийж байгаад , тэгээд хувилгаан ширээнд гараад ...тэгээд явсан шүү.

Гантулга: Яг Байшинтын хийд дээр сууж байсан хүн үү?

Чиндэг: Үгүй. Хошуу хийд дээр.

Гантулга: Аан Хошуу хийд дээр сууж байгаад урагшаа гараад...?

Чиндэг: Тийм.

Гантулга: Тэгээд урд хуралдаа сууж байгаад буцаж орж ирээд...?

Чиндэг: Тийм, тийм. Тэгээд унзадаа хийж байгаад. Ганданд очоод бас дахиад унзадаа хийсэн.

Гантулга: Байшинтын хийдийн тухай, Жасрай гэгээний талаар?

Чиндэг: Жасрай гэгээнтэн яахав, одоо энэ Очирдарь багшийн чинь шавь нь байсан юм гэнэ лээ.

Гантулга: Очирдарь багшийн?

Чиндэг: Тийм, Шавь нь...Ээ солиотой юм , солио тусчихсан юм шиг элдэв янгзын юм яриад л зогсож байдаг гэж л эртнээс ярьдаг байсан.Миний багшийг дагаад явж байсан Галданпилжаа нар хичнээн хувьтай улс явахн бол доо гээд л гадаа гараад зогсчихсон, залбираад зогсчихдог байсан гэсэн.

Гантулга: Аль дүр нь?

Чиндэг: Одоо тэр урд гэгээн гэдэг нь...Миний багшийг дагаад явж байсан хичнээн хувь заяатай Галдандилжаа нар байх болт оо гээд л ...Юу гэв, солиоров уу гээд л /инээв/ Тэгж л ярьдаг байсан гэдэг энэ тэр гээд хүн ярьдаг юм.

Гантулга: Тэгэхээр чинь Буурал гэгээний чинь багш нь Очирдарь лам болох нь , тиймээ?

Чиндэг: Тийм.

Гантулга: Тэгэхээр ахмад хүн байна аа ,даа?

Чиндэг: Тийм.

Гантулга: Тэгээд тэр урагшаагаа Очирдарь хувилгаан бол бас сүүлийнх нь дүр үү, тиймээ? Тэр Богд гэгээнээс дүү хүн болж...?

Чиндэг: Дүү, дүү мөртөнгөө багш нь байсан байгаа юм.

Гантулга: Аа мөн мөн. Насаар бол дүү?

## МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Чиндэг: Насаар дүү. Зүгээр тэр багш нь байсан хүн байгаа юм.Тэр чинь Буурал гэгээн гэдэг чинь бүр тэр баруун талаас Хавсрын тэндээс залсан хүүхэд юм гэнэ лээ л дээ.Хүүхэд. Тэгээд амаа тамхи их татах, нээх урт гаанстай. Том гуулин толгойтой гаанстай. Тэгээд тэр аваачаад лам дээлэндээ өвөртлөчихдөг, тэгээд өвөрт нь багтахгүй.

Гантулга: Аан овойгоод?

Чиндэг: Тэгээд ард нь хөшүүртэй, хоёр талаас нь тэвхэдчихчэг, тийм байдаг байсан гэж ярьдаг юм.Тэгээд төмөр толгойтой, бугуй толгойтой бөгөлзөг зүүчихсэн, эндээ.Тэгээд байс хийж байгаад л багшид мөргөнө гээд явдаг.Хэдэн шавь нараасаа дагуулаад , эгэл бараа бологч дагуулаад л.Тэгээд л ирэхэд нь ойрхон юм чинь урдаар тусгай орон байр бэлдчихсэн байдаг.Тэгээд л ирэхлээр нь тэрэнд нь угтаад л багшид бараалхана гээд л ...Өнөө гаанс нь ард тэвхтэй, тамхи нь хэвээрээ. Тэгээд л орж ирж багшид мөргөдөг.Тэгээд багш шавь юу болж байна гээд л тэгээд л за одоо түгдамдаа очиж амар амар гээд л явна. Тэгээд л ирээд л тамхиа татаад л тэр орон дээр хэвтэж байгаа нь магадгүй, сууж байгаа нь магадгүй тэгээд л нөгөө таяг ийм том гаансаар нэг тамхи нэг сороод л /ярилцлага түр завсарлав/ Тэгээд л нэг сороод л , за энүүнийг аваачаад тийш нь цацчих даа гээд нэг ламд хэлдэг тийм хүн байсан юм гэнэ лээ.

Гантулга: Шилүүстэйн хурал чинь болвол Тамгатайн хийд байсан гэж байгаа биз?

Чиндэг: Тийм.

Гантулга: Тэр том тэргүүн лам нь ?

Чиндэг: Тэр Шар Цорж гэж нэртэй хүн байсан юм гэнэ лээ, хамгийн эхлээд. Дөчин ламын баталгаатай Шар Цорж гэж лам. Тэрний хойд дүрийг л энэ Шавруун ламыг ярьдаг юм даа.Сайн мэдэхгүй, тэгээд хичнээн жилийн урд юм мэдэхгүй. Хошууны ганц том угтаа хийд нь Шилүүстэй гэх юм билээ, анхан.

Гантулга: Байшинтын хийд дээр чинь энэ Шавроон лам, Очирдарь лам эд нар чинь байж байсан гэж?

Чиндэг: Өө наашаа цаашаа яваад л энэ Очирдарь лам эд нар чинь байлгүй дээ.

Гантулга: Бас ойрхон юм чинь?

Чиндэг: Газар ойрхон юм чинь.

Гантулга: Энэ Маанийн хурал бол жижигхэн хурал байсан уу?

Чиндэг: Жижигхэн хурал байсан юм гэнэ лээ. Би мэдэхгүй юм.

Гантулга: Шавруун ламын хурал бол цам энэ тэр юмтай байсан байх даа, тиймээ?

Чиндэг: Мэдэхгүй юм, тэрнийг ерөөсөө мэдэхгүй юм.

Гантулга: Та Байшинтын хийдийн нг дуганы талаар , Цагаан дуганы талаарЮ

Чиндэг:Тэр Байшинтын цагаан дуганыг чинь сүүлд саяхан л урласан юм шүү.Энэ Номгоны хийдийн Хамарчулуун, Цэдэн гэж хоёр банди байсан байгаа юм. Тэгээд энэ Номгоны хийдээсээ очиж Байшинтын зуны хурал босгох гэж хоёулаа тэнд очиж хурсан. Тэгээд би нэг энэ хөдөө адуу хайж давхиж байгаад тэр Цэдэнгийн гэдэг айлд хүрээд оччихсон юм байгаа юм.Тэгсэн тэр Хамарчулуун гэж нээх сайхан гэсгүй, намайг бага байхад гэсгүй хийж байсан байгаа юм, сайхан тухтай томоотой, түгжийсэн том бор лам байсан юм.Би магтаал ерөөлд дургүй, ер нь унших юмандаа ...Тэгээд л цагаан арын магтаалаар чинь босоод зогсчихно доо. Нэг алхаад л нэг

## МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

хүүхдийн өмнө, нэг магтаал өнгөрөөд л нэг алхаад л нэг хүүхдийн өмнө.Тэгээд л муухан шиг алдаад байгаа хүүхдийг нь тэрүүгээр нь заагаад л тэгээд л нахиулаад л тэгээд байдаг гэсгүй байсан юм , тэр.Өөрөө дүү сайтай ,уншлага сайтай.Тэгээд л тэгж байгаад л хэд гуравь сайхан сунаж тавьчихаад л .Тэгээд л яваад өгсөн.Тэгээд магтаалаар чинь сууна гэж байхгүй. Одоотой адил, одоо тэр Гандангийн уншиж байга магтаалыг би нэг очиж чагнаж ээ , нэг хэдхэн юм уншчихаад л .Заримыг нь татах юм даа. Тэгээд л нөгөө юу руугаа орчих юм.Маниусыг жоохон байхад зүгээр гучин хэдэн магтаалыг өдөрт. Шинийн нэгнээс авахуулаад арван таван хүртэл өдөрт шувтан.Тэгээд тэр хооронд чинь бас нэг юмыг нь татна. Тэгээд тийм өдөр их урт байсан билүү, магтаал цагтаа багчихаад л байдаг байсан.Тэгэхдээ шөнө л тарна л даа, зүгээр .Одоогоор юм л бол арван нэг гээд л тардаг байсан байх л даа. Өглөө цогчингоо хурчихаад л , цогчингоос ирж дээхэн дуганаа татчихаад л , ирж цайгаа чанаж уучихаад л ...

Гантулга: Эргэж буцаад л ?

Чиндэг: Эргэж буцаад л дурдангаа татна,тэгэхээр зэрэг номоо хурчихна. Тэгээд л хурчихна.

Гантулга: Та тэр баганын тухай нэг ярьж байсан даа?

Чиндэг: Тэгээд би тэр хоёр өвгөний яриаг сонссон юм байгаа юм.Үгүй ээ Байшинтын цагаан багана үгүй мөн том, үгүй мөн бүдүүн баганатай байж билээ хө гэж.Үгүй ээ чи бид хоёр нэг зуны хурал очиж хурах гээд хоёр талаас нь ингэхэд чи бид хоёрын гар дөнгөж хүрч байж билээ гэж ярьж байсан байгаа юм. Хоёр хүүхдийн гар , хоёр бандийн гар хоёр талаас ингэхэд дөнгөж гарын үзүүр нь хүрч байсан гэж.

Гантулга: Маш том, их бүдүүн баганатай л болох нь?

Чиндэг: Их бүдүүн баганатай. Тэгээд нураах гээд нурааж дийлэхгүй, машинаар татаж буулгасан юм гэж нэг үг байдаг юм аа.Нураагаад дийлэхгүй.

Гантулга: Байшинтын тэр Дүйнхорын дацан дуган, Дүйнхорын дацан гэнэ үү бас нэг түүр ?

Чиндэг: Аа тэр гол дуганаа л урдаар барьсан л даа, тэр цогчин дуган.Тэр Эзний голоос модыг нь гэрээ хийж, үлс явуулж. Тэр Эзний голоос...

Гантулга: Тэр Эзний гол нь хаана байдаг юм?

Чиндэг: Одоо тэр Далайхүүгийн тэр дэнж...

Гантулга: Аан Өвөрмонголын нутагт байдаг юм үү?

Чиндэг: Тийм, тэр Өвөрмонголын Эзний хошуу гэж ярьж байгаа юм. Тэндээс модыг нь авсан юм гэнэ лээ.Тэгээд л ийм ийм урттай, тэмээ тэмээнд ачиж болохоор тийм моднууд энд тэндгүй нэл байдаг байсан юм.Тэрнийг татаж шалбалж байсан юм гэнэ лээ.Зузаан ч гэж яг л оросын дүүф мод гээд хатуу мод байдаг байсан юм.Яг л тэрэн шиг.

Гантулга: Бас хиймэл овоо мовоо байсан гээд дурдсан?

Чиндэг: Тийм. Дээр үед Цэдваа гээд сүрхий лам байсан юм гэнэ лээ, манай энд. Газар лусыг чинь эзэмшихсэн ёстой нэг тийм хүн...

Гантулга: Хэн гэнэ ээ?

## МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Чиндэг: Цэдваа. Тийм лам байсан юм гэнэ лээ.Тэгээд тэр ламыг гарч ирж, өнөө хоёр хошууны улсууд дуганы мод бэлдүүлнэ гээд очиж гэрээ хийдэг. Одоо суурийг нь аваад зааж өгсөн газар нь очдог юм байна л даа, тэр лам нь. Эндээс, эндээс мод ав гэж.Тэгээд ерөөсөө аль болдоггүй, аль дошгин газрынхаа хаягийг зааж өгсөн байхгүй юу, цаад улсууд нь доршгин газрынхаа.Тэгээд тэрний эцэст энэ Буурал гэгээн лам нь гэсэн байх аа. Тэр Жүд баавгайг хэсэг танхайдүүхан банди нартай...

Гантулга: Хамтад нь явуулаад ?

Чиндэг: Хамтад нь явуулаад цуг мод бэлдүүлэхээр.Тэгээд тэр Жүд баавгайг даалт даагаад. Тэгээд хэсэг танхайдүүхан шавь шар өгөөд явуулчихдаг юм байна аа. Тэгээд явахад нь үүдэн дээрээ цөгцтэй юм барьчихсан зогсож байдаг юм байна.Тэгээд л хааяа нэг мод хийдэг газар дээр нь явж байдаг.Тэгж байснаа нэг модыг зостчихоод энүүнийг гурав хоногоос нааш битгий ааваарай гээд тэгчихээд явдаг. Тэгээд л нөгөөдөхийг нь тэгсэн болчихоод л , нөгөө танхай банди нар чинь захаас нь хөөгөөд л хяргаад байхыг бодолгүй яхав дээ.Тэгчихээд л жоохон шороо атгачихаад л энүүнийг гурав хоноод аваарай, энүүнийг хоёр хоноод аваарай гэхихээд л явчихдаг байсан байгаа юм.Тэгээд нэг өдөр нэг бүдүүн мод хөрөөдөөд өнөө банди нар чинь салгачихаж гэнэ ээ.Сул болчихсон, тэгээд унадаггүй.Тэгээд л нөгөө хоёр гурван банди нар чинь түлхээд байдаг , ер унадаггүй гэнэ ээ.Сул болчихсон, тэгээд суурин дээрээ байж л байдаг. Тэгээд л бүр салахгүй болохоор хаячихаад явж байсан. Пэр пар гээд л чимээ гарсан, нөгөө мод нь өнхрөөд унаж байна гэнэ ээ.Тэгээд л тэгэхэд нь очиж тогтоочихоод л , тэгээд л үгүй сонин юм даа гээд л .Хүрээд ирсэн чинь үүдэн дээрээ зогсож байна гэнэ. Аа та нар нэг мод унагах гэж баахан зүдэрцгээв үү дээ гээд л өмнөөс нь зогсож байна. Өөрөө дамшиглаад л /инээв/ Одоо тийшээ энэ Цагаан дээсний түүрх гэдэг юм байна уу, үгүй юу?

Гантулга: Байна ,байна.

Чиндэг: Тэрэн дээр чинь сууж байсан хүн юм гэнэ лээ.Тэр чинь тэр зурхайн дацан гэж байсан юм гэнэ лээ.

Гантулга: Цагаан дээснийх үү?

Чиндэг: Тийм.

Гантулга: Хоёр Цагаан дээсний дуган гээд мөн үү?

Чиндэг: Тэр чинь энэ Зөөлөнгий өвөрт яг зам дээр нэг түүрх бий ш дээ.Тэр чинь тэр Доолой сууж байсан гэж ярьдаг юм билээ.

Гантулга: Нэлээн том дацан байсан юм шиг байна лээ. Хөөрхөөн талбай байна лээ?

Чиндэг: Тийм.

Гантулга: Та тэр Шавроон ламын талаар?

Чиндэг: Тэр чинь Ядав Зоогийн ус гээд тэрүүхэн тэнд тусгай усанд байж байдаг байсан хүн юм гэнэ лээ.Зурхайн дацан гэж тэнд байсан юм гэнэ лээ. Тэр жадангар гэж нэг хоор өвс гарчихаад дийлдэхээ байсан, нэг жил. Тэгсэн тэр Доров ламд хэлсэн. Тэгсэн хоёр гурав хоног ном уншаад л суугаад байсан. Нэг өглөө тэгээд хуцанжороо гэж нэг хонгор шувуу байдаг юм.Хаа байгаа нь ч мэдэгдэхгүй. Тэр тэгсэн чинь газар ухаад л байгаад байх юм.Нөгөө хортой өвсийг чинь ухаж идээд л...

## МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Гантулга: Жадангар аа?

Чиндэг: Тийм, мал халдварлуулдаг нэг тийм өвс байдаг юмаа. Ургамал. Тэр л дийлдэхээ байсан гэж байгаа юм. Тэгсэн нэг өглөө л тэр хуцанжороо гэдэг шувуу л зүгээр чухам газар хөдөлж байсан гэж байгаа юм. Тэгээд л хоёр гурван өглөө тэгж байгаад л нэг өглөө боссон өнөө шувуу хайччихсан юм бүү мэд, байхгүй. Хэн мэдэхэв, өнөө жадангар ч байхгүй, шувуу ч байхгүй. Тэгээд одоо тэр хуцанжороог бүтээчихсэн байх нь уу, яасан юм тийм сэрхий хүн байсан юм гэнэ лээ.

Гантулга: Тэр ороо хийд тэр газрын нь эзэн нь л байж дээ, тиймээ?

Чиндэг: Тэр лусыг л ... ямар ч байсан нэг барьчихдаг хүн байсан.

Гантулга: Овоотын хийдийн чинь эзэн лам нь ямар хүн байсан юм?

Чиндэг: Мэдэхгүй ээ.

Гантулга: Тэр Гоёотын хурал гээд л байна, тэр Дуганых, Хоолтынх, тэр Ганзагат гэж байна?

Чиндэг: Тэр Ганзагат гэж тийм юм байгаа юм.

Гантулга: Жижигхээн?

Чиндэг: Жижигхээн.